

**УВС АЙМАГ
“ИХ БАРИЛГА УВС” ХУВЬЦААТ КОМПАНИ**

2026 оны 3 сарын 16 өдөр

Дугаар 02

Улаангом

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ**

Монгол улсын компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 64 дүгээр зүйлийн 64.2, 67-р зүйлийн 67.1 дэх хэсэг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг” тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “ИХБАРИЛГА-УВС” ХК-ний ээлжит хурлыг 2026 оны 04-р сарын 27-ны өдрийн 14 цагт (орон нутгийн цагаар) компанийн байранд зарлан хуралдуулсугай.
2. “ИХБАРИЛГА-УВС” ХК-ний хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:
 - 2.1 Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
 - 2.2 Компаний нэрийн зөрчлийг арилгаж Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХХК-д бүртгэлтэй “Ихбарилга” ХК болгож өөрчлөх, үүнтэй холбоотойгоор дүрэмд өөрчлөлт оруулах.
 - 2.3 Цүнхэг төсөлд шаардлагатай хөрөнгө оруулалтын дүнг батлах.
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 4-р сарын 08-ны өдрөөр тогтоосугай
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдахтай холбогдуулан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдээлэл”-ийг хавсралт №1-р “Хурлын дэг”-ийг №2-оор, хувьцаа эзэмшигчдээс авах “Саналын хуудас”-ыг хавсралт №3-аар, “хурлын зарыг” хавсралт №4-р тус тус баталсугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдахтай холбогдуулан доорх бичиг баримттай 2026 оны 04-р сарын 10-наас 2026 оны 04-р сарын 26-ны өдрийн 17 цаг хүртэл (Орон нутгийн цагаар) компанийн байранд ирж танилцах эрхтэй болохыг дурьдсугай. Үүнд
 - 5.1 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай ТУЗ-ын тогтоол болон тус тогтоолд холбогдох хавсралт материалууд
 - 5.2 Компанийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн Аудитийн дүгнэлтийн хуулбар.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдлийг хавсралт материалын хамт 2026 оны 03-р сарын 19-ний дотор “Санхүүгийн зохицуулах хороо” болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д хүргүүлэх, Хавсралт №4-т заасны дагуу хурлын зарыг 2026 оны 03-р сарын 21-ны дотор өдөр тутмын 2-с доошгүй сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг телевиз, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д цахим хуудсаар дамжуулан тус тус нийтэд мэдээлэх, 2026 оны 03-р сарын 25 ны дотор брокер, дилерийн компанид хүргүүлэхийг ТУЗ-ын нарийн бичигт даалгасугай.
7. Саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2026 оны 04-р сарын 10-наас 2026 оны 04-р сарын 26-ны өдрийн 17 цагаар тогтоосугай.
8. Хурал зохион байгуулах комиссын даргаар А.Баатарыг томилсугай.
9. Хурлын бэлтгэлийг хууль, журмын дагуу сайтар зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.СУМЬЯА

"ИХБАРИЛГА-УВС"-ХК-ийн ТУЗ-ийн
2026 оны 03-р сарын 16-ний өдрийн
02 тоот тогтоолын Хавсралт №1

ИХБАРИЛГА-УВС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	ИХБАРИЛГА-УВС
Хаяг:	Увс аймаг, Улаангом сум 12-р баг худалдааны гудамж 207 тоот
Хурал хуралдах өдөр, цаг:	2026 оны 04-р сарын 27 ,14цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Компанийн байр, хурлын заал
Хуралын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2026 оны 03-р сарын 16
Олон нийтэд зарлах огноо:	2026 оны 03-р сарын 20
Бүртгэлийн өдөр:	2026 оны 04-р сарын 09
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг, брокер дилерийн компанид хүргүүлэх огноо:	2026 оны 03-р сарын 25
Хүргүүлсэн огноо:	2026 оны 03-р сарын 25
Саналын хуудас хүлээн авах сүүлийн өдөр:	2026 оны 04-р сарын 26
Хурлын даргын нэр:	А.Сумъяа
Тоололгын комиссын дарга, гишүүдийн нэр:	Б.Болормаа
Баримт, бичгийн жагсаалт /хавсралтаар/	
Баримт бичгийн хуудасны тоо	

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА



А.БААТАР

“ИХБАРИЛГА-УВС”-ХК-ийн ТУЗ-ийн
2026 оны 03-р сарын 16-ний өдрийн
02 тоот тогтоолын Хавсралт №2

“ИХБАРИЛГА УВС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

№	Хуваарь	Хариуцах этгээд	Хугацаа
1	Хурлын ирц бүртгэх	Тооллогын комисс	14:00-14:15
2	Хурлын ирцийг мэдээллэх		
3	Хурлын дарга хурлыг нээж, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах;	Хурлын дарга	14:15-14:40
4	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, асуулт хаиулт, санал авах	Хурлын дарга	14:40-15:20
5	Хэлэлцэх асуудал тус бүрээр санал хураалт	Тооллогын комисс	15:20-15:30
6	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах;	Тооллогын комисс	15:30-15:40
7	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах;	Хурлын дарга	15:40-15:55
8	Хурлыг хаах		16:00

“ИХБАРИЛГА-УВС”-ХК-нийн ТУЗ-ийн
2026 оны 03-р сарын 16-ний өдрийн
02 тоот тогтоолын Хавсралт №3

“ИХБАРИЛГА-УВС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛЫН ХУУДАС №1

Хувьцаа эзэмшигчийн овог нэр:				
Итгэмжлэлийн дагуу төлөөлж байгаа төлөөлөгч этгээдийн тухай тайлбар:				
Регистрийн дугаар:				
Санал өгөх хувьцааны тоо:				
Утасны дугаар:				
Цахим хаяг:				
Хэлэлцэх асуудал:		зөвшөөрсөн	татгалзсан	түдгэлзсэн
1	Компанийн 2025 оны үйл ажилгааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах.			
2	Компаний нэрийн зөрчлийг арилгаж Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХХК-д бүртгэлтэй “Ихбарилга” ХК болгож өөрчлөх, үүнтэй холбоотойгоор дүрэмд өөрчлөлт оруулах.			
3	Цүнхэг төсөлд шаардлагатай хөрөнгө оруулалтын дүнг батлах.			
4	Бусад			

Заавар: та өөрийн саналыг (+) тэмдэгээр бичнэ.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг: / /

Тооллогын комисс бөглөх хэсэг:

Саналын хуудсыг хүчинтэйд тооцож тоолсон эсэх: тийм үгүй.....

Саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл:

“ИХБАРИЛГА-УВС”-ХК-нийн ТУЗ-ийн
2026 оны 03-р сарын 16-ний өдрийн
02 тоот тогтоолын Хавсралт №4

“ИХБАРИЛГА-УВС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Хурлын төрөл:	Ээлжит
Хурал хуралдах өдөр,цаг:	2026 оны 04-р сарын 27 өдөр 14 цаг (Орон нутгийн цаг)
Хурал хуралдах газар:	Увс аймаг, Улаангом сум 12-р баг худалдааны гудамж 207 тоот
Бүртгэлийн өдөр:	2026 оны 04-р сарын 09
Хэлэлцэх асуудал:	1. Компанийн 2025 оны үйл ажилгааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах. 2. Компаний нэрийн зөрчлийг арилгаж Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХХК-д бүртгэлтэй “Ихбарилга” ХК болгож өөрчлөх, үүнтэй холбоотойгоор дүрэмд өөрчлөлт оруулах. 3. Цүнхэг төсөлд шаардлагатай хөрөнгө оруулалтын дүнг батлах. 4. Бусад
Баримт бичигтэй танилцах:	2026 оны 04-р сарын 26-ны 17 цаг хүртэл
Холбоо барих:	88008916, 88705807,99452529